



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 дөрөв

Дугаар 25

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар нийт 5,199.1 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я. Төмөрбаатарт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдэж ажиллах;

2.2. Тухайн жилийн үр дүн, орлого, зардлын төлөвлөгөөг эдийн засгийн тооцоо судалгаатай төлөвлөж батлуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

2.3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэж байгаа ажиллагааг таслан зогсоох;

2.4. Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэр, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн зүүн урд байршилтай оюутны байр, конторын зориулалттай, үл хөдлөх хөрөнгийн Y-2203010462 дугаар бүхий гэрчилгээтэй, 375 м.кв барилгын суурийг болон 391 м.кв газрын хамт эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй худалдсан байх тул Монгол Улсын Их Сургууль болон "Тунгалаг Эрдэнэ" ХХК-ийн хооронд байгуулсан 2011 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 2011/19 дугаартай худалдах, худалдан авах гэрээг цуцлах санал хүргүүлж, гэрээг цуцлах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авах;

2.5. Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай 4 айлын зориулалттай 983 м.кв эзэмшил газар дээр багш, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 98 айлын орон сууц 2016 онд ашиглалтад орсноос хойш 6 орон сууц, 2 гарцаашийг МУИС-ийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлж өгөхөөр тохиролцсон байсан боловч одоог хүртэл шилжүүлээгүй байгаа асуудлыг эд хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулан хүлээн авч, хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлд тусгаж, орон сууцыг зохих зориулалтаар ашиглах;

2.6. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2019 оны 1 дугээр улиралд багтаан ирүүлэх.

0000051


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 07 дугаар сарын 42-ний өдрийн
зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт.

Монгол Улсын Их Сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт.

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Үнийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авсан	Захираг, Санхүү, төлөвлөлт хариуцаан дэд захираг, холбогдох ажиллагсад	4,720.3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авсны дагуу үндсэн хөрөнгө олж авах;
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Захираг, Санхүү, төлөвлөлт хариуцаан дэд захираг, Хангамж, үйлчилгээний газар, холбогдох ажиллагсад	478.8	Худалдан авах ажиллагааг тооцоо судалгаатай төлөвлөж, хуль зохион байгуулж, тайлганах.
	Зөрчил, дутагдлын нийт дүн		5,199.1	